



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/135

Номгон

Газрын харилцааны талаарх асуудалд
тогтмол хяналт тавьж ажиллах ажлын хэсэг
байгуулах тухай

Мэргэжлийн хяналтын газар Газрын тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Геодези зураг зүйн тухай хуулиудын хэрэгжилт тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартыг хангах ажлын хүрээнд Газар олголтыг шалгах 2.10 кодтой хяналтын хуудсыг ашиглан 2015-2020 онуудын баримтад хийсэн хяналт шалгалтаар Газрын тухай хуулийг зөрчин 53 нэгж талбарт газар олголт хийгдсэн байх тул дахин ийм төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлж Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."н", 30 дугаар зүйлийн 30.1.5, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тухайн жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газар зохион байгуулалт, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдэж буй газар олголт, аймгийн Засаг даргын захирамжийн төсөл зэрэг газрын харилцааны талаарх асуудалд тогтмол хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Г.Энхбаяр – Аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч

Гишүүд: Д.Сарангарав – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Т.Хишигбаатар – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Уянга – Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч


1210339

2.

Нарийн бичгийн дарга Б.Намуун - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2.Тус хяналт шалгалтыг тогтмол хийж, хууль тогтоомжийн дагуу, үр дүнтэй зохион байгуулан улирал тутамд цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлтийг Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг (Г.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН